

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2012 ОНД

I. ӨРХ, ХҮН АМ: Оны эцэст 16.0 мянган өрх, 55.6 мянган суурин хүн амтай болж, урьд оноос өрх 217-оор, хүн ам 520-оор өслөө. Нийт өрхийн 47.1 хувь буюу хүн амын 48.9 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн 28.9 хувь нь байшинд амьдарч байгаа бөгөөд урьд оноос 1.3 пунктээр өслөө. Төвлөрсөн халаалттай орон сууцанд 1322 өрх өмьдөрч байгаа нь урьд оноос 137 өрхөөр өссөн байна.

Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт хүн амын 66.3 хувийг 15-59 насныхан, 28.2 хувийг 0-14 насныхан, 5.5 хувийг 60 ба дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 50.8 хувьтай болж, хөдөлмөрийн насны 2 хүнд 1 тэжээлгэгч хүн ногдож байна.

66 багаас Баруун-Урт сумын 5-р баг 863 өрх, 2880 хүнээр тэргүүлж байна.

2012 онд 364 хүн шилжин ирж, 747 хүн шилжин явсан нь урьд оноос 166-421 хүнээр буурсан байна. Шилжин явагсдын 61.7 хувь нь Улаанбаатар хот руу шилжжээ. .

II. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 12.8 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 1.6 хувиар давж биелсэн нь өмнөх оныхоос 3.0 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Бүх сум төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, 11.1 хувиар буюу 383.3 сая төгрөгөөр давууллаа.

Орон нутгийн төсвийн зарлага 9.5 тэрбум төгрөг болжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 2.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

III. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр Арилжааны банкуудын ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 46.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 11.8 тэрбум төгрөгөөр буюу 33.6 хувиар өсчээ.

Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 25.3 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 8.5 тэрбум төгрөгөөр буюу 50.6 хувиар өссөн байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Малтай болон малчин өрх, малчид: Аймгийн нийт өрхийн 57.9 хувь болох 9.2 мянган өрх аминдаа 2255.4 мянган мал тоолуулсан нь нийт малын 98.9 хувийг эзэлж байна. Малчин өрх 6530 байна.

Нийт малтай өрхийн 58.6 хувийг 200 хүртэл малтай өрх эзлэх болж жил дараалан буурч, харин 200-аас дээш малтай өрхийн тоо жил дараалан өсч, чанарын өөрчлөлт гарч байна. 284 өрх мянгаас дээш мал тоолуулж, шинээр 67 мянгат малчин төрлөө.

Мал аж ахуй: Мал сүрэг урьд оноос 199.2 мянгаар өсч, 2.3 сая мал тоологдсны дотор тэмээ 9.8 мянга, адуу 183.6 мянга, үхэр 151.1 мянга, хонь 1090.8 мянга, ямаа 845.3 мянга болж, тэмээнээс бусад 4 төрөл дээрээ өслөө.

Нийт сумд малаа өсгөсний дотор Сүхбаатар сум 5 төрөл дээр, бусад бүх сумд тэмээнээс бусад 4 төрөл дээр нь өсгөлөө. Нийт сумдаас 5 сум 200.0 мянгаас дээш мал тоолуулсны дотор Баяндэлгэр сум 295.8 мянган мал, 19.2 мянган үхэр, 141.4 мянган хонь, 116.7 мянган ямаагаар, Сүхбаатар сум 1.3 мянган тэмээгээр, Эрдэнэцагаан сум 26.9 мянган адуугаар аймагтаа тэргүүлж байна.

Малын тоог багаар авч үзвэл: 66 багийн 23 нь 40.0 мянгаас дээш малтай байгаагийн дотор хамгийн олон малтай нь Баруун-Урт сумын 8-р баг 92.2 мянган малаар тэргүүлж байна.

Нийт 94.1 мянган хээлтэгч тоологдсон нь нийт малын 43.6 хувийг эзэлж байна.

Оны эхний эх малын 87.2 хувь буюу 787.8 мянга нь төллөж, 786.1 мянган төл бойжуулж авлаа.

Оны эхний малын 1.0 хувь болох 20.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оноос 2.6 дахин цөөн мал хорогдсон байна.

Газар тариалан: Энэ онд төмс 64.5 га-д, хүнсний ногоо 23.7 га-д тариалж, 683.2 тн төмс, 223.1 тн хүнсний ногоо хураасан нь урьд оноос төмс 5.5 хувиар, хүнсний ногоо 5.2 хувиар тус тус дээгүүр байна.

Хадлан 11.8 мян.тн, гар тэжээл 731.0 тн-ыг бэлтгэсэн нь урьд оноос өссөн байна.

V. БЕЗНИС РЕГИСТРИЙН САН: Бизнес регистрийн санд 602 ААНБ бүртгэлтэй байгаагаас 522 буюу 86.7 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй ААНБ урьд оноос 81-ээр, үйл ажиллагаа явуулж байгаа нь ААНБ нь 31-ээр нэмэгдсэн байна

Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл: ХХК 47.5 хувь, төрийн байгууллага 22.6 хувь, ЗБН 5.6 хувь, ТББ 9.8 хувь, ББН 6.5 хувь, Хоршоо 5.7 хувийг тус тус эзэлж байна. Мөн Хувийн хэвшил 74.7 хувийг эзэлж байна.

VI. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 33.4 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 4.9 тэрбум буюу 17.4 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн нийт борлуулалт 143.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 44.5 тэрбум төгрөг буюу 44.8 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, хэвийн боов, бялуу, мөхөөлдөс, нүүрс, цайрын баяжмал, яндан, шургуулга, түлээний авдар, лааз, түмпэн, ваань, угаалтуур, галын хайч, дээл, хантааз, буриад

гутал, сандал, ширээ, вакуум цонх зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өсч, шинээр 20-иод нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь аж үйлдвэрийн салбарын өсөлтөд нөлөөлсөн байна.

VII. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Нийт 14.3 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь урьд оноос 87.1 хувиар өссөн байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 221.1 мян.тн ачаа, давхардсан тоогоор 59.2 мян. хүн тээвэрлэж, ачаа эргэлт 55.3 сая.тн км, зорчигч эргэлт 33.5 сая хүн км-т хүрсэн байна Тээсэн ачаа өнгөрсөн оноос 33.5 мян.тн буюу 17.9 хувь, зорчигчдын тоо 34.1 мян зорчигч буюу 135.8 хувиар тус тус өсчээ. 8.1 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 53.1 хувиар өссөн байна.

Тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр 7154 тээврийн хэрэгсэл үзлэг тооллогод хамрагдсан нь урьд оноос 11.2 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: 70.9 хувь буюу 5.1 мянга нь автомашин, 27.4 хувь буюу 2.0 мянга нь мотоцикл, 1.1 хувь буюу 79 нь чиргүүл, 5.7 хувь буюу 41 нь механизм байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 488.2 сая төгрөг болсны дотор хүн амаас 223.0 сая төгрөг орсон нь урьд оноос нийт орлого 43.6 хувиар, хүн амаас орох орлого 33.8 хувиар тус тус өссөн байна.

VIII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 9.9 хувиар өссөний дотор холбооны үнэ тарифаас бусад бүх бүлгийн үнэ тариф өссөн байна. Тухайлбал: Мах, махан бүтээгдэхүүн 41.3 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 66.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 18.5 хувь, хүнсний бараа 11.8 хувь, хувцас, бөс бараа гутал 10.2 хувь, гэр ахуйн тавилга, бараа 9.2 хувь, тээвэр 8.7 хувь, боловсролын үйлчилгээ 10.0 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

IX. БОЛОВСРОЛ,СОЁЛ: 2012-2013 оны хичээлийн жилд 354 бүлэгт 9.9 мянган хүүхэд суралцаж байгаагийн 49.5 хувь нь эмэгтэй сурагчид байна.

1-р ангид 917 хүүхэд элсэн орж, бага ангид 5.1 мянга, дунд ангид 3.2 мянга, ахлах ангид 1.7 мянган хүүхэд суралцаж байна.

Энэ жил 15 сургуульд 948 хүн ажиллаж байгаагийн 668 буюу 70.5 хувь нь эмэгтэй багш байна.

ЕБС-ийн нийт ажиллагсадын дотор үндсэн багшийн эзлэх хувь аймгийн дүнгээр 53.8 хувьтай байгаагийн дотор 1-р 10 жил, Бүрэнцогт, Тэмүүлэл сургуульд 66.2-72.2 хувь нь үндсэн багш нар байна.

Соёл: Хөгжимт жүжгийн театр 2012 онд 58.6 мянган үзэгчдэд 62 тоглолтоор үйлчилж 30.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Музей: 2.0 мянган үзмэрээр 1.2 мянган хүнд үйлчилж, 1.4 сая төгрөгийн орлого олжээ.

Нийтийн номын сан: 29.5 мянган уншигчдад 44.5 мянган номоор үйлчилж 162.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

X. ЭРҮҮЛ МЭНД: 1248 эх амаржиж, 1259 хүүхэд төрсөн бөгөөд 1-5 хүртэлх насандаа 5 хүүхэд эндсэн нь урьд оноос 3-аар цөөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 715 болж, урьд оноос 63-аар өссөний дотор гахайн хавдар, тэмбүү, трихоминиаз, салхин цэцэг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

XI. АЖИЛГҮЙЧҮҮД: НХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 780 болж, өмнөх оныхоос 32-оор буурчээ. Ажилгүй иргэдийн 73.6 хувь нь 15-34 насны залуучууд, 39.5 хувь нь бүрэн дунд, 23.9 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 1324 хүн шинээр бүртгүүлж, 1143 хүн ажилд орсны дотор 811 нь шинэ ажлын байр байна.

XII. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО: 3-р улирлын түүвэр судалгаанд хамрагдсан 40 ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин, орлогыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилалаар авч үзэхэд: Санхүү, уул уурхай, цахилгаан эрчим хүчний салбар өндөр үзүүлэлттэй байна.

XIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 7.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогод 0.2 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 13.7 хувиар давж биелсэн.

6138 өндөр настанд 12.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 2.4 тэрбум төгрөгийг 5.6 мянган иргэнд, улсын төсвөөс 15.6 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 69.6 мянган иргэнд тус тус олгосны дотор хүний хөгжил сангаас 14.2 тэрбум төгрөгийг 61.8 мянган иргэнд олгосон байна.

XIV. ГЭМТ ХЭРЭГ: Энэ онд 261 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оноос 23 хэргээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас 43 хүн нас барж, 77 хүн гэмтэж, ААНБ, иргэдэд 253.3 сая төгрөгийн хохирол учирсны 240.3 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 218 хүн сэжиглэгдсэний 11.5 хувь нь бүлэглэнгээр, 28.4 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 3095 хүн эрүүлжигдсэн нь урьд оноос 117 хүнээр өсчээ.

XV. ТӨСӨЛ: Малын индексжүүлсэн даатгал төсөл 13 суманд хэрэгжиж 590 өрхийг хамруулж 83.9 сая төгрөгийн хураамж авсан нь урьд оноос өрхийн тоо 30.2 хувиар буюу 264 өрхөөр буурч харин хураамж 30.1 хувиар буюу 19.4 сая төгрөгөөр өссөн байна.

2011 онд МИД төсөлд хамрагдсан сумдаас 2012 онд Түмэнцогт сумын 82 өрхийн ямаанд 1.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 288 иргэнд 706.7 сая төгрөгийн зээл олгож, 678 ажлын байр бий болгосны дотор Эрдэнэцагаан сумын 32 иргэн 81.2 сая төгрөг, Баруун-урт сумын 73 иргэн 196.8 сая төгрөгийн зээл авч, ажлын байртай болсон нь бусад сумдаас дээгүүр байна.

Тогтвортой амьжиргаа-II төслөөр 274.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, тохижуулалтанд 20.5 сая, засварт 15.7 сая, шинэ бүтээн байгуулалтанд 24 сая төгрөг зарцуулжээ.

XVI. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Нийт өссөн дүнгээр 6886 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 6557 иргэнд 612.16 га газар өмчлүүлэх шийдвэр гарсан байна. Үүнээс: 2012 онд 871 иргэн өргөдөл гаргаж, 691 иргэнд 59.03 га газрыг өмчлүүлэх шийдвэр гарчээ.

Нийт 3147 иргэн газрын гэрчилгээгээ авч баталгаажуулсны дотор 2012 онд 392 иргэн газар өмчлөлийн гэрчилгээгээ авсан байна.

XVII. ДААТГАЛ: Даатгалын кампаниуд 28.3 мянган иргэнийг 13 төрлийн даатгалд хамруулан 351.9 сая төгрөгийн хураамжийн орлого оруулсан бөгөөд 523 иргэнд 32.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байна.

